

## ЭРНСТ ГЕЛЛНЕР БА НҮҮДЛИЙН ФЕОДАЛИЗМЫН ТАЛААРХ МЭТГЭЛЦЭЭН

Н.Н. Крадин

1988 онд Эрнст Геллнер "Төр ба нийгэм Зөвлөлтийн сэтгэлгээнд" (*State and society in Soviet thought*) хэмээх номоо хэвлүүлжээ. Нэрнээсээ аваад үзэхэд зохиогч энэ номондоо зөвлөлтийн (оросын) антропологичдын зарим бүтээлүүдэд дүн шинжилгээ хийсэн нь тодорхой байна. Гэвч эл номын шүүмж зөвлөлтийн антропологийн сэтгүүлүүдэд нийтлэгдээгүй юм. Зөвлөлтийн эрдэмтэд энэ бүтээлд тоомжиргүй хандсан гэж хэлж болно. Гэвч үнэн хэрэгтээ, энэ номыг шүүмжлэхээр бэлдэж байсан юм. Тухайн үед өрнөдийн нөлөө, ялангуяа Геллнерийн бүтээлүүдийн шууд нөлөөгөөр зөвлөлтийн идэр залуу антропологичид эл шүүмжийг бичихээр завдаж байсан билээ. Энэ шүүмжийг өөр өөрийн мэргэшлийн чиглэлээр оролцогч бүр хийхээр тохиролцсон юм. Харин олон хүн оролцсон энэ ажилд өөрт ноогдсон хэсгээ гүйцэд хийгээгүйгээс эл санаачлага талаар өнгөрчээ.

Энэхүү нийтлэл нүүдэлчдийн нийгмийн талаарх миний шүүмжийн хэсгийн дэлгэрүүлсэн хувилбар юм. (бас нэг өөр хэсэг нь Азийн үйлдвэрлэлийн аргад зориулсан байв). Эхлээд эл өгүүллийг зөвхөн орос хэлээр хийж, 1990-ээд оны дундуур хэвлэгдэн гарсан юм (Крадин, 1996). Арай хожуу антропологт оруулсан Геллнерийн хувь нэмрийн талаарх хэлэлцүүлгийн үед арай өргөн хүрээтэй судлаачдад зориулсан өгүүлэл бэлтгэх санаа төрсөн юм. Харин англи хэлтэн судлаачдад орос хэлээр өрнөсөн [мэтгэлцээний] олон нарийн ширийн зүйлсийг нэмэлт тайлбаргүйгээр хүргэх боломж муу байв. Тийм учраас орос хувилбарыг дахин нилээд боловсруулах шаардлагатай болж, үүний үр дүнд эл өгүүлэл бэлэн болсон юм.

Нүүдлийн феодализмын асуудал Зөвлөлтийн антропологид (буюу этнологид) дөнгөж 1934 оноос тавигдсан юм. 1920-1930-аад онуудад арга зүйн хувьд олон үзлийн найралт ёс<sup>1</sup> дэлгэрч байсан. Нэг хэсэг судлаачид нүүдлийн нийгмийн үүсэл гарлыг хүй нэгдэлтэй холбон тайлбарлах хандлагатай, нөгөө хэсэг нь нүүдэлчид өөрийн төр ёс, улс гүрэн байгуулж байсан хэмээн үзэж байлаа. Харин бас завсарын үзэл ч байсан юм. 1930-иад оны дундуур Сталины дарангуйлал тогтож, үй олныг хамруулсан хэлмэгдүүлэлт болон зөвлөлтийн хүмүүсийн эсрэг аймаглан устах үйлдэл хийсний дараа түүхэн зохиолуудад нүүдлийн феодализмын онол давамгайлах хандлагатай болжээ. Гэсэн хэдий ч ортодокс монизмын хүрээнд өөрийн гэсэн ревизионистууд байсаар байв. Тэд нүүдлийн феодализмын талаарх ноёлж байсан төсөөллүүдэд эргэлзэх болжээ. Албан ёсны үзлийн хүрээнд нүүдэлчдийн феодализмд газар өмчлөл үндэс болж байсан бол, ревизионистуудын хувьд мал өмчлөх явдал гол нь гэж маргаж байжээ. Ортодокс ба ревизионистуудын хоорондын зөрчил хэд хэдэн хурц мэтгэлцээнд хүргэж, нэн ялангуяа 1953-1955 онуудад ихээхэн зөрчилдөх байдалд хүрчээ. ЗХУКН-ын XX их хурлын дараа тоталитар дарангуйлал зөөлрөх хандлагатай болж, нийгмийн шинжлэх ухаанд үзүүлэх үзэл суртлын дарамт суларчээ. Харин энэ байдалд ихэнхи судлаачид шинжлэх ухааны асуудлуудаар судалгааны шинэ арга зам хайж, уламжлалт бус шийдэл эрэлхийлэх болжээ. Тэр үед нүүдэлчдийн талаарх феодалын бус тайлбарууд гарсан байна. Нүүдэлчдийн нийгмийг феодалын өмнөх ба эртний нийгмийн ангийн шинж чанар, үзэл ухал<sup>2</sup>, Азийн нүүдэлчдийн формац оршин тогтнож байсан тухай үзлийн (Үүний тухай дэлгэрэнгүй уншиж танилцахыг хүсэж байвал: Хазанов 1975, Коган 1980, Халаль

<sup>1</sup> Олон үзлийн найралт ёс- плюрализм, үүнийг олон ургалч үзэл гэж орчуулсан нь бас бий. үзэл ухал- концепция гэсэн үг

Исмаил 1983, Khazanov 1984, Марков 1976, 1998, Крадин 1992, 2001, Масанов 1995) үүднээс тайлбарлаж байв.

ЗХУ задарсны дараа эл мэтгэлцээн оросын утга зохиолуудад үргэлжлэн явагджээ. Үүний сацуу, урьд өмнө дэвшигдэж байсан үзэл онолууд ямар нэгэн хэмжээгээр хэвээр хадгалагдан үлджээ. Гэвч нүүдэлч-малчдын нийгмийн хөгжлийн онцгой зам байсан гэдгийг үндэслэх оролдлогууд хамгийн их маргаанд хүргэжээ. Нүүдлэхүйн онцлог- нүүдлийн үйлдвэрлэлийн аргын үндэс нь мал аж ахуй байх бөгөөд түүний дотоод агуулгад чухам юу орж байна, мөн газар тариалан эрхлэгчдийн “энх эзэнт гүрэн” байсан уу? гэсэн асуултын эргэн тойронд уг асуудал төвлөрөн өрнөжээ. Формацийн онолын дангаар ноёрхсон үзлийг даван туулж байгаа эл үеэр иргэншлийн онолын үүднээс нүүдлэхүйг авч үзэх оролдлогуудыг хийжээ. (Kradin 2001, 2002).

Нүүдэлчдийн феодализмын асуудлыг Геллнер хоёр ч удаа хөнджээ. Эхлээд Анатолий Хазановын “*Nomads and outside world*”, (*Нүүдэлчид ба харь ертөнц*) гэдэг номын редакторын өмнөтгөлд, дараа нь “*State and society in Soviet thought*” хэмээх нэгэн сэдэвт зохиолоо нүүдэлчдийн нийгэм-эдийн засгийн харилцааны хэлэлцүүлэгт зориулжээ. (Gellner 1984: ix-xxv, 1988: 92-114).

Геллнер зөвлөлтийн нүүдэл судлалд зохих үнэлгээ өгсөн байна. Орос, зөвлөлтийн эрдэмтэд нүүдэл судлалд илүү амжилт олох ёстой, учир нь оросын түүх ямагт талын ертөнцтэй холбоотой байсан билээ. Геллнер тухайн бүлэгтээ асуудлын хоёр аспектыг хөнджээ. Онолын хувьд марксист арга зүйн эврик боломжуудыг хөндөж, мөн түүх бичлэгийн үүднээс авч үзэн, зохиогчид, тэдний бүтээлүүдэд үнэлгээ өгчээ.

Онолын аспектад, нүүдэлчдийн асуудал марксизмын хувьд Азийн үйлдвэрлэлийн аргатай дүйхүйц асуудал болж байгааг цохон тэмдэглэжээ. Нүүдэлчдийн нийгэм, ер нь дорно дахин тэр чигээрээ хүй нэгдлээс аваад коммунизмд хүрэх хүн төрөлхтний формацийн үе, шатлалд нийцэхгүй байгаа юм. Учир нь, гаднаа хөдөлгөөнгүй, ороомог давтамжтай хувьсаж буй нүүдэлчдийн нийгмийг хүн төрөлхтний хөгжлийн прогрессивист марксизмын онолын хүрээнд (Европ төвт үзлийн үүднээс) тайбарлах боломжгүй юм.

Нүүдэлчдийн нийгэм-эдийн засгийн байгууллыг марксист ойлголтын аппаратын хүрээнд дүрслэхэд бэрхшээлтэй байдаг нь өөр нэг ноцтой асуудал болж байна. Марксизмын үүднээс авч үзэхэд, нүүдэлчдийн төлөвшилтийн хүрээнд аж ахуй, соёлын маягийн хувьд газар тариалантай харьцуулахад үйлдвэрлэлийн хэрэгсэл [мал] хувийн өмчинд хамаагүй түрүүнд шилжсэн мөртлөө суурьшмал иргэншилтэй харьцуулахад нийгэм-эдийн засгийн хөгжлөөр нүүдэлчид хоцрогдонгүй байгаа нь ямар учиртай юм бэ? Нүүдэлчид хувийн өмчтэй бөгөөд ихээхэн хэмжээний хуримтлал буй болгож байгаа юм бол тэднийг хүй нэгдлийн формацид хамааруулах нь хэр зэрэг зөв бэ? Нөгөө талаас авч үзвэл төрийн түшмэл ёс байхгүй байсан юм бол нүүдэлчдийг хүй нэгдлээс хэрхэн гарсан гэж үзэх вэ?

Эцсийн эцэст, түүхэн материализмын арга зүй, зарчмын үүднээс авч үзэхэд – суурь, давхрагын хоорондын харьцааны хууль зэрэг үндсэн зарчмын дагуу нүүдэлчдийн нийгмийг яаж тайлбарлах вэ? Марксын онолоор бол суурьт гарсан өөрчлөлтүүд нь зайлшгүй давхрааг (хувьсгалт хэлбэрээр) өөрчилдөг. Нүүдэлчдийн эдийн засгийн суурь – бэлчээрийн мал аж ахуй олон зуун жилийн турш бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Эртний, дундад зууны болон бүр хожуу үеийн нүүдэлчид байгаль цаг уурын нөхцөлтэй шууд хамааралтай сүргийн бүтэц, тээвэрлэхэд хялбар гэр ахуйн хэрэгсэл, аж ахуйгаа хөтлөх төсөөтэй

---

· мир империи  
· прогресс- дэвшил  
· бюрократ аппарат

технологитой байжээ. Харин нүүдэлчдийн "давхраа" сууриас тэс ондоо, тогтворгүй байжээ. Нүүдэлчид гарал нэгтэй, эсвэл өөр өөр аймгуудаас бүрдсэн аймаг ханлигууд үүсгэж, хүчирхэг манлайлагчдын удирдлагаар асар том эзэнт гүрэн байгуулж, эсвэл жижиг салангид хаант улс болон задарч, тэр бүү хэл бүр жижиг бүрдэлийг бий болгож байжээ. Зөвлөлтийн онолчид түүхийн марксист диалектикаас нүүдлэхүйг төдийгүй, нүүдлийн феодализмын онолыг бий болгосон гэж Э.Геллнер тайлбарлажээ. Нүүдлийн феодализмын онолын үндэслэгч хэмээн ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн гишүүн Борис Владимирцов, Сергей Толстов нарыг зүй ёсоор үзжээ. Харин 1939 онд хилс хэргээр буудуулсан Эрхүүгийн профессор Николай Кузьминий "Түрэг-Монголын феодализмын асуудалд" (1934) хэмээх номыг Геллнер олж үзээгүй бололтой. Геллнер Владимирцовын тухай Дорно дахины судлаач томоохон эрдэмтэн хэмээн хүндэтгэлтэйгээр хандаж, түүнийг ортодокс марксизмыг хоосон магтагчдын хүрээнд хамааруулж үзээгүй юм. Владимирцовын хийсэн ихэнх тайлбарууд эзэнт гүрний үед хамааралтай байгааг Геллнер тэмдэглэж, дараах зөв зүйтэй асуудлыг дэвшүүлжээ. Үүнд: Феодалын парадигмыг нүүдэлчдийн эзэнт гүрний бус нийгмүүдийг авч үзэхэд хэрэглэх нь зүйтэй юм. Геллнер: Владимирцов марксизмын сонгодгуудаас эшлэл бараг татаагүй түүнийг магтан дуулагчдаас ангид байгааг бас тэмдэглэсэн байна. Үнэндээ, энд Геллнер туйлбартай байж чадаагүй, тэрбээр Владимирцовт үнэнхүү тал өгч, түүнийг нүүдлийн феодализмын онолыг үндэслэгчдийн нэг хэмээн үзсэн байна. Үнэн хэрэгтээ, нүүдлийн марксист феодализмын онолыг боловсруулахад Владимирцовын оруулсан хувь нэмрийг дэндүүлсэн байна. Владимирцов бол хэл шинжлэлийн чиглэлийн Дорно дахины судлаач том эрдэмтэн байсан юм. Тэр марксизмд гүн нэвтэрсэн нь юу л бол. Үүний тулд монгол хэлний олон аялгуунуудыг нягтлан судлах бус Марксын Das Capital болон Энгельсийн Ursprung-ийг судлах хэрэгтэй байсан юм. "Монголчуудын нийгмийн байгуулал" (Общественный строй монголов)-д марксист зүйл юу байна гэвээс ганц Энгельсийн дээр дурьдсан ном болон баримт дээр үндэслэн, эзэнт гүрний үеийн монголын нийгэмд хэд хэдэн феодалын институт байгааг нотлохыг оролдсон юм. Владимирцов феодализмыг эрх зүйн тогтолцоо гэж авч үзэж байгаа нь сонирхол татаж байгаа юм. Хэд хэдэн газар тэрбээр XIX зууны сүүлийн Оросын нэрт түүхч Павлов-Сильванскийгаас эш татжээ. Харин хаана ч хүй нэгдлийн дараа орох феодализмын тусгай үйлдвэрлэлийн аргын тухай дурьдсан зүйл алга байгаа юм.

Яагаад Владимирцовыг нүүдлийн феодализмын онолын үндэслэгч гэж үзэх болсон бэ? Миний үзэж байгаагаар, эл асуултын хариуг зөвлөлтийн судлаачид археологич Чайлд болон Владимирцовын талаар зэргэд харьцуулсан үнэлгээнээс олж харж болох юм. Л.С. Клейн "Зөвлөлтийн археологийн өнгө төрх" (Феномен советской археологии) хэмээх номондоо амьд сэрүүн байхад нь Чайлдад харьцангуй болгоомжтой хандаж байсан. Харин түүнийг нас барсаны дараа марксист археологийн хөгжилд оруулсан хувь нэмрийг өндөрөөр үнэлэх болсон гэжээ.

"ЗХУ-д хилийн чинад дахь зүүний судлаачдад хандах талаар энэ нь ердийн үзэгдэл байсан байна. Амьд сэрүүн байхад нь, сонор сэргэмжтэй бай, тэрээр яаж эргэж шарвахыг хэн мэдлээ, харин чиний таалсан тодорхойлтууд чиний эсрэг бууна (ЗХУ-д улс төрийн ял эргэж буудаг, халдварладаг байсан юм.) Харин талийгаач марксист бол сайн марксист юм. Түүний үзэл үүрд марксист хэвээр үлдэнэ."(1993:116).

Магадгүй, "Монголчуудын нийгмийн байгуулал"-аас иймэрхүү үр дүн харж болно. Зохиогч нь нэртэй эрдэмтэн байсан бөгөөд номоо нийтлэгдэхээс гурван жилийн өмнө зуурдаар нас баржээ. Үүний дараа, түүнд ямар ч санааг зовлон зүдгүүргүй "нааж" болох байлаа. Тэдний хувьд монголын дундат зууны судлалд

оруулсан хувь нэмрээр нь хагас зууны турш бурхан шүтээн болгож иржээ. Хожим нь Владимирцов бусдын шүүмжлэлийн аятайхан бай болсон аж. "Нүүдлийн феодализм"-ын онолын гол эсэргүүцэгч Толыбеков, Марков нарын шүүмжлэлийн сум ихэнхдээ Златкин буюу Потаповын эсрэг хандаагүй байна. Тэд *Монголчуудын нийгмийн байгуулал-ын* эсрэг хандсан хэдий ч феодализмын тухай Владимирцовын ойлголтын эсрэг бус харин Сталины сэдвүүдийн эсрэг чиглэсэн байжээ. Б.Я.Владимирцов болон зөвлөлтийн ихэнхи феодализм судлаачдын дэвшүүлэн тавьсан ойлголтуудыг ангилж зааглах гэсэн Фёдоров-Давыдовын оролдлого (1976) төдийлөн амжилтанд хүрч чадсангүй.

Владимирцовоос ялгаатай нь Толстов Геллнерт таалагдаагүй бололтой. Түүнийг Сталины хоосон сэдвүүдийг шууд нэвтрүүлэгч гэж үзжээ. Геллнер Толстовын түүхэн тодорхой баримтуудын их зонхийг марксизмын сонгодог бүтээлүүдээс эшлэл татаж тайлбарласныг цохон тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч ийнхүү таалахгүй байгаагийн гол учир нь энэ биш юм. Марксист ангийн тэмцлийн онолыг бодит амьдралтай холбох гэсэн Толстовын тууштай оролдлогууд Геллнерийн зэвүүцлийг төрүүлжээ. Нүүдэлчдийн нийгмийн феодалын болон ангийн шинж чанарыг нотлохдоо, Толстов өөрийнхөө (орчин) үеийн малчдын нийгэм дэх (Сталины сэдэвт зохицуулж) завьшигч нударганчуудтай хийх анги, ангийн тэмцлийн хурцдаж байгааг үндэслэн батлахад хүрчээ. Энэ нь Дундад Ази, Сибирь ба Казакстан зэрэг нүүдэлчин ард түмнүүдийн эсрэг үй олноор аймаглан устгах шинжлэх ухааны үндэслэл гэгчийг зөвтгөж өгчээ.

Үүнээс улбаалан, Геллнер нүүдлийн феодализмын тухай цаашдын мэтгэлцээний явцыг дэс дарааллаар авч үзжээ. Тэрбээр, нүүдэлчдийн нийгмийн феодализмын шинж чанарын тухай сэдэв нийт зөвлөлтийн шинжлэх ухаанд аажмаар тархсан байдлыг зүй ёсоор харуулж, мэтгэлцээний шинэ давалгаа 1954 оны Ташкентын чуулгантай холбогдуулан гарсан гэж үзжээ. Геллнер энэ мэтгэлцээнд түлхүү оролцсон Зиманов, Потапов ба Толыбеков нарыг цохон тэмдэглэжээ. Геллнер эл маргааныг авч үзэхдээ чухам хэний талд байгаагаа илэрхийлжээ. Харамсалтай нь, түүний хараанаас Толыбековын талын Казахын угсаатны зүйч Шахматов гарсан байна. Тэрбээр догматик шүүмжлэгчдийн эсрэг Толыбековын талыг илэрхий дэмжиж, байр сууриа илэрхийлсэн байна. Нүүдлийн феодализмын сөрөг онолыг Толыбеков шүүмжилснийг Геллнер маш чухал гэж үзжээ. Харин Потапов болон түүний хамтран зүтгэгчид (дээр дурьдсан Шахматоваас бусад нь) албан ёсны байр сууриа хамгаалж байсныг Геллнер таалаагүй юм. Тэрбээр Потаповын бүтэц зөрчилтэй, түвэгтэй байгааг шүүмжилжээ. "Түүний нотолгоонууд хачин" хэмээх дүгнэлтэнд английн антропологич хүрчээ. (Gellner 1988: 104).

Геллнер бас Толыбековын сул талуудыг зүй ёсоор авч үзжээ. Нэг талаас, тэрбээр нүүдэлчдийн феодализмын онолыг шүүмжилж, нөгөө талаас тэрбээр феодалын чиглэлтэй (эцгийн эрхт ёс бүхий феодалын) үзлийн хүрээнд нүүдэлч малчдын түүхийг хөндөж байна гэж үзжээ. Харамсалтай нь энд бодит учир шалтгаан байсан юм. Азийн үйлдвэрлэлийн арга зөвлөлтийн анхны мэтгэлцээнд бут ниргэгдсэний дараа дотоодын [ЗХУ] зөвхөн нэг шугамтай формацийн парадигмын хүрээнд түүхэн үйл явц өрнөж байв. Зөвлөлтийн үед боловсрол олж авсан ихэнх судлаачид (Толыбеков, тухайлбал 1907 онд мэндэлжээ), дэлхийн түүхийг тайлах олон хэмжигдэхүүний талаар ойлголтгүй байсан байж болох юм. Сталины эрин үеийн дэлхийн түүхийн локомотив зөвхөн нэг шугамаар явах боломжтой байлаа. Хэрэв урагшаа биш бол "алхам урагш, алхам хойшоо."

Нүүдэлчид дэлхийн түүхийн диалектикт тууштай орж чадахгүй үлдэж байлаа. Тэдний түүхийн замналд ямагт улаан гэрэл асаж байв. Тийм учраас, Геллнерийн үзэж байгаагаар нүүдэлчдийг түүхийн хүрдэнд оруулахын тулд Толыбеков казахуудыг Хаант Оросын бүрэлдхүүнд орсон нь дэвшилтэй хэмээн

хамгаалжээ (Gellner 1988: 114). Энд Геллнер Толыбековыг “түүхийн өмнөх” ард түмнүүдийг арай хөгжингүй (“түүхэн”) нийгмүүдийн хүрээнд түүхэн байр суурь эзлэнэ гэж дэлхийн түүхээс зоригтой хассан [Жан Поль] Сартрын байр суурьтай адилтгажээ. Сартрын байр суурийг Леви-Стросс шударгаар шүүмжилж, Геллнер [Леви-Стросстой] санал нийлж байна. Гэвч Толыбековыг өмгөөлж хэлэхдээ “нэг шугамыг дагагч” байгаагүй юм гэжээ. Толыбеков дэлхийн түүхийн гол замын зэрэгцээ хэд хэдэн жим гаргах гэж оролджээ. Тэрбээр өөрийн үзлээ батлахын тулд улс төр- эдийн засгийн нэлээд сайн үндэслэл гаргах гэж оролдож, суурьшмал иргэншлийн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл газар байхад, нүүдэлчдийн хувьд газар хөдөлмөрийн зүйл бөгөөд мал үндсэн хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байжээ гэсэн үндэслэгээ гаргажээ. Энэ талаас нь авч үзвэл Толыбековыг ЗХУ-ын эрдэмтдийн дунд дотоодын марксизмын олон шугамт түүхэн үйл явцыг сэргээх гэсэн оролдлого хийсэн гэж үзэж болох юм.

Толыбековын дараа “нүүдлийн феодализмын” эсрэг аян дайнд Марков нэгдэн оржээ. Тэрбээр 1967 онд түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертацидаа боловсруулсан өвөрмөц “нүүдэлчдийн үйлдвэрлэлийн арга”-ын тухай санаа нь үндсэндээ олон шугамт шинжтэй байсан бөгөөд таван гишүүнт догматик тогтолцоонд аюул учруулахуйц байлаа. Харамсалтай нь Геллнер эл онолтой танилцаагүй бололтой. Тэрбээр “Азийн нүүдэлчид” (*Кочевники Азии*) хэмээх Марковын диссертаци дээрээ үндэслэн бичсэн номоос эшлэл татсан байна. Эл номонд Азийн үйлдвэрлэлийн аргын тухай түүний зоригтой санаа нүүдэлчдийн ангит нийгмийн өмнөх үед байгаагаар солигдсон байна.

Марковын Златкин, Лашук, Фёдоров-Давыдов нартай хийсэн маргаануудыг Геллнер анхаараагүй бололтой. Яагаад ч юм, Москвагийн төвийн хэвлэлүүдэд нийтлэгдсэн зөвлөлтийн эрдэмтдийн өгүүллүүдийг бараг ашиглаагүй байна.

Иймэрхүү зүйлсийг орхигдуулсан хэдий ч Геллнер зөвлөлтийн нүүдэл судлалын цаашдын дэвшлийг Марков, Хазанов нарын бүтээлүүдтэй зүй ёсоор холбон авч үзжээ. Зөвхөн казахуудын түүхийн баримт сэлтэд тулгуурласан Толыбековын бүтээлүүдээс ялгаатай нь Марков, Хазанов нар арай өргөн цар хүрээтэй түүхэн харьцуулалт, баримтууд дээр үндэслэн дүгнэлт гаргалгаа хийжээ. Геллнер эл хоёр зохиогчийн хувь нэмрийг ерөнхийд нь нүүдлийн феодализмын онолыг шүүмжлэх үүднээс тууштай авч үзэж үнэлжээ. Үүнтэй холбогдуулан тэрбээр Марков болон Хазановыг адилхан дүгнэлтэнд хүрсэн гэж үзсэн байна (Gellner 1988: 109-12).

Геллнерын эдгээр дүгнэлтүүдийн олон зүйлтэй санал нийлж болох юм. Марков судалгаандаа феодалын эсрэг чиглэсэн гэж цохон тэмдэглэсэн байдаг (1976,1998). Марковын “Азийн нүүдэлчид” бүтээлийн дийлэнх бүлгүүд олонд танил (урьд нь феодалын хэмээн тайлбарласан ) баримтуудыг тэс ондоо зарчим өнцгөөс авч үзжээ. Калиновская (1996) “тэрбээр эл онолыг үндэслэл баримттайгаар нураасан” гэж үзжээ. Нүүдэлчдийн нийгмийг феодалын хэмээн тайлбарлахад Хазанов арай зөөлөн маягаар бас шүүмжилсэн юм (Khazanov 1981: 173 note 3). Мөн түүнчлэн эл хоёр зохиогчийн нүүдэлчдийн эдийн засаг, нийгмийн бүтэц болон бэлчээрийн [мал аж ахуй] зэргийг тодорхойлоход ямар нэг хэмжээний адилсал байсныг ажиглаж болох юм. Эцсийн эцэст энэ хоёр зохиогч тодорхой хэмжээгээр Ибн-Хальдуны бэлчээрийн [мал аж ахуйн] давтамжтай хувьсалын тухай бодол санаанд хүрчээ (Gellner 1988: 111,113). Харин сайхь хоёр дүгнэлтийн хэсэгтээ хоорондоо зөрчилдөж байв. Марковын хувьд нүүдэлчид ангит нийгмийн давааг давж чадсангүй ээ. (Тэрбээр нүүдэлчдийг феодалын өмнөх, ангит нийгмийн өмнөх эсвэл нүүдлийн үйлдвэрлэлийн арга эхний формацид оруулах зэргээр олон нэр томъёоллоор нэрлэжээ). Харин

\* Адилсал- сүүлийн үед identity, идентичность зэрэг үгсийг ингэж орчуулж байгаа билээ.

Хазановын хувьд нүүдэлчид бие даасан хувьслын хүрээнд эртний төрт ёсны бүрдэлд хүрэх боломжтой гэж үзжээ. Энэ нь зарчмын ялгаатай зүйл гэдгийг хүлээн зөвшөөрөх буй заа.

Зөвлөлтийн нүүдэл судлалыг тоймлон дүгнэхдээ төгсгөлийн хэсэгт “Хүй нэгдлийн түүхийн” (*Истории первобытного общества*) II ботийг хөнджээ. Марксист биш ч гэсэн тэрбээр Шнирельманы нүүдлийн мал аж ахуй хэдийгээр аж ахуй, үйлдвэрлэлийн хэлбэр байсан хэдий ч “ангит нийгэмд хүрэх эсвэл ангит нийгмийн эртний хэлбэрт хүрэх боломж өгдөггүй” гэсэн дүгнэлтийг тун тааламжтай эш татсан байна. Мөн түүнчлэн иймэрхүү санаануудыг Чайлдын бүтээлүүдээс олж авчээ. Энэ санааг зэгсэн сайн эрдмийн бүтээлийн хэмжээнд авч үзэж, эрдэм шинжилгээний төвийн нэр хүндтэй хэвлэлд Бромлей эмхтгэн, түүний удирдлагаар олноор хэвлэн гаргасан нь английн судлаачийн үзэж байгаагаар зөвлөлтийн нүүдэл судлалд гарсан зарчмын өөрчлөлтийг илэрхийлжээ. Зөвлөлтийн антропологийн ухааны ирээдүйн хувьд “феодалын маягийн тайлбарлагчдын урсгал” дүүрчээ гэсэн өөдрөг үзэл санааг Геллнер дэвшүүлжээ (Gellner 1988: 113).

Байдал ийм байсан болоосой! Геллнерийн эш татсан эл бүтээл олонхийн үзэл санааг илэрхийлэхгүй байгааг умартжээ. Тухайн үеийн ЗХУ-ын ШУА-ийн Угсаатны зүйн хүрээлэнгийн хүй нэгдлийн түүхийн салбарын (Абрам Першицийн удирдлага дор) 1970-1980-иад оны хамгийн сайн эрдмийн хамт олон эл бүтээлийг бэлтгэсэн гэдгийг санах хэрэгтэй юм. Хэрэв Эрнст Геллнер арай өргөн хүрээнд нүүдэл судлалын бүтээлүүдтэй танилцсан бол тийм их өөдрөг дүгнэлт гаргахгүй байсан болов уу? Би бараг 10 жил их сургуулиудад олон янзын хичээл зааж байна. Харамсалтай нь марксист байхын тулд Марксыг эш татах шаардлагагүй юм. Сурах бичиг номонд Маркс, Энгельс болон Лениний эшлэл алга болжээ. Гэсэн хэдий ч эрдэм шинжилгээний байгууллага, тэнхим, салбаруудад [марксистууд] хүмүүс нь хэвээр үлджээ.

Өөр нэг хэсэг судлаачид формаци гэдэг нэр томъёог иргэншил гэдэг үгээр шууд сольж байна. Хэрвээ тэд өмнө нь дэлхийн түүхэнд байр сууриа батлахын тулд өөрийн өвөг дээдсийг феодализмаар дамжсан гэж байсан бол одоо тэд иргэншил гэдэг нэр зүүн тайлбарлах оролдлого хийх болжээ. Ингэхдээ, олонхи нь иргэншлийг өөрийн соёлын тогтолцоо (Шпенглер эсвэл Тойнби) хэмээн үзэлгүй, харин Морган эсвэл Энгельс нар шиг дэлхийн түүхийн хөгжлийн үе шатыг ойлгосоор байна. Геллнер нүүдэлчдийн феодализмыг үгүйсгэгч зөвлөлтийн хэсэг антропологичдыг сайшаан үнэлж байлаа. Гэсэн хэдий ч нүүдэлч малчдын онцлогуудыг нүүдэлчдийн дотоод хөгжлийн логикоос бүрэн төгс тайбарлах боломжгүй болой. Энэ санаанууд Оуэн Латтиморын алдарт Inner Asia frontier of China (Lattimore, 1940)- бүтээлээ дэвшүүлсэн нүүдэлчдийн нийгмийн онцлогуудыг соёлын экологи болон нүүдэлч малчдын суурьшмал газар тариалан эрхлэгч хөршүүдтэйгээ харилцан ойлголцох зүй ёсны хэрэгцээнээс гарсан юм. Үүнээс хойш, эхлээд Хазанов (Khazanov 1984) дараа нь Барфилд (Barfield 1981, 1992, 2000) эл асуудалд анхаарлаа төвлөрүүлжээ. А.М.Хазанов нүүдэлчдийн нийгмийн томоохон нэгдлүүд (тэрбээр тэднийг төрийн эртний хэлбэрүүдэд оруулсан байдаг) гаднах (суурин) орчин болон нүүдэлчдийн хоорондын тэгш бус [ассиметрийн] шинжтэй харьцааны үр дагавар байсан гэж үнэмшилтэйгээр нотолжээ. Эдгээр санаануудыг тэрбээр өөрийн бүтээлдээ хураангуйлан дүгнэжээ. Т.Барфилд нүүдэлчид газар тариалан, суурьшмал иргэдийн төрийн хэлбэрийг хуулбарласан гэдэг тайлбарыг эрс эсэргүүцэж, талын нүүдэлчдийн нийгмийн төвлөрлийн түвшин, суурьшмал газар тариалангийн нийгмийн улс төрийн нэгдлийн түвшингөөс шууд хамааралтай гэж үзжээ. Хожим нь, талынхны улс төрийн үүсэл гарлыг газар тариалангийн ертөнцтэй холбоотой байсныг дундад зууны Дорнод

Европын нүүдэлчдийн баримт сэлтээс улбаалан Голден хөгжүүлжээ (Golden 1992, 2001).

Марксист шинжлэх ухааны хувьд иймэрхүү санаануудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйл болой. Формацийн онолоор авч үзвэл төр зөвхөн дотоод учир шалтгаан -үйлдвэрлэлийн хэрэгслийн хөгжил ба ангийн тэмцлээс үүсэх ёстой билээ. Энэ үүднээс авч үзэх юм бол Хазанов Скифийн нийгмийн хувьслын тухай номондоо илэрхийлсэн өмнөх санаанууд нь нилээд ревизионист шинжтэй гэхээр байгаа юм. Нүүдэлчдийн нийгмийн онцлогуудыг зөвхөн (эсвэл голлон) дотоод хөгжлийн үүднээс тайлбарлах уламжлал оросын нүүдэл судлалд одоо хүртэл зохих байр суурь эзэлж байна (Калиновская 1996, Кычанов 1997, Марков 1998 болон бусад). Гэсэн хэдий ч орос хэлээр буй зохиолуудад Латтимор-Хазанов-Барфилд нарын шугамыг баримтлагчид ч гэсэн байсаар байна (Масанов 1991, Крадин 1992, 2002, Фурсов 1995, Скрынникова 1997, Васютин 1998, Крадин, Бондаренко 2002, Kradin, Bondarenko, Barfield 2003 ба бусад).

Эрнст Геллнер зөвлөлтийн нүүдэл судлалд ямар нэг нөлөө үзүүлсэн үү? Ихэнхи олон шугамт шинжтэй бүтээлүүд *State and Society in soviet thought* нийтлэгдсэний дараа гарчээ. Тийм учраас шууд нөлөө байхгүй байх. Гэвч миний үзэж байгаагаар энэ бүтээлийг “*Наци и национализм*” шиг Орост хөрвүүлэн нийтэлсэн бол оросын антропологичдад ихээхэн нөлөөлөх байсан болов уу. Геллнерийн эл ном болон Оросын конструктивистуудын гол төлөөлөгч Валерий Тишковын бүтээлүүд төр ёсны өмнөх (primordial) Бромлейн марксист онолыг няцаахад их үүрэг гүйцэтгэснийг хэлэх хэрэгтэй юм. Гэсэн хэдий ч Геллнер Хазановын *Nomads outside world (Нүүдэлчид ертөнцөөс гаднах)* хэмээх бүтээлийг Их Британид хэвлүүлэхийн төлөө үлэмжийг хийснийг мартаж болохгүй юм. Хазановын нэр ЗХУ ба Өрнөдөд ихэд нөлөөтэй байж, түүний санаанууд миний үеийн судлаачдад чухал хэрэгцээ болсоныг мартаж аргагүй. Энэ үүднээс Эрнст Геллнерийг дэлхий дахины нүүдэл судлалд чухал үүрэг гүйцэтгэж, мөн түүнчлэн оросын нүүдэлчдийн нийгмийн антропологит олон шугамт уламжлал бий болгоход томоохон хувь нэмэр оруулсан гэж үзэж болно.

Орчуулсан С.Түвшин,  
Ж.Болдбаатар нар

## Ном зүй

- Васютин, С.А. 1998. Социальная организация кочевников Евразии в отечественной археологии. Автореф. дис. ... канд. ист. наук. Барнаул.
- Владимирцов, Б.Я. 1934. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Л.: Изд-во АН СССР.
- Калиновская, К.П. 1996. О кочевничестве в связи с книгой В.В. Матвеева "Средневековая Северная Африка". Восток, № 4: 153-158.
- Клейн, Л.С. 1993. Феномен советской археологии. СПб.: Фарн.
- Коган, Л.С. 1981. Проблемы социально-экономического строя кочевых обществ в историко-экономической литературе (на примере дореволюционного Казахстана. Автореф. дисс. ... канд. экон. наук. М.
- Козьмин Н.Н., 1934. К вопросу о турецко-монгольском феодализме. Иркутск.
- Крадин, Н.Н. 1992. Кочевые общества. Владивосток: Дальнаука.
- Крадин, Н.Н. 1996. Э.Геллнер о кочевом феодализме. Четвертая Дальневосточная конференция молодых историков. Владивосток: 11-19.
- Крадин, Н.Н. 2001. Общественный строй кочевников: дискуссии и проблемы. Вопросы истории, № 4: 21-32.
- Крадин, Н.Н. 2002. Империя Хунну. 2-е изд. М.: Логос.
- Крадин, Н.Н., Бондаренко, Д.М. 2002 (ред.). Кочевая альтернатива социальной эволюции. М.
- Кычанов, Е.И. 1997. Кочевые государства от гуннов до маньчжуров. М.: Восточная литература.
- Марков, Г.Е. 1967. Кочевники Азии: Автореф. дис. ... д-ра ист. наук. М.
- Марков, Г.Е. 1976. Кочевники Азии. Структура хозяйства и общественной организации. М.: Изд-во МГУ.
- Марков, Г.Е. 1998. Из истории изучения номадизма в отечественной литературе: вопросы теории. Восток, № 6: 110-123.
- Масанов, Н.Э. 1991. Специфика общественного развития кочевников-казахов в дореволюционный период: историко-экологические аспекты номадизма. Автореф. дис. ... д-ра ист. наук. М.
- Масанов, Н.Э. 1995. Кочевая цивилизация казахов (основы жизнедеятельности кочевников). Алматы: Социнвест; М.: Горизонт.
- Скрынникова, Т.Д. 1997. Харизма и власть в эпоху Чингис-хана. М.: Восточная литература.
- Толстов, С.П. 1934. Генезис феодализма в кочевых скотоводческих обществах. Изв. ГАИМК, Вып. 103.
- Толыбеков, С. Е. 1971. Кочевое общество казахов в XVII - начале XX века. Политико-экономический анализ. Алма-Ата: Наука.
- Федоров-Давыдов Г.А. 1976. Общественный строй кочевников в средневековую эпоху. Вопросы истории, № 8: 39-48.
- Фурсов, А.И. 1995. Восток, Запад, капитализм. Капитализм на Востоке во второй половине XX века. Отв. ред. В.Г. Растянников. М.: 16-133.
- Хазанов, А.М. 1975. Социальная история скифов. Основные проблемы развития древних кочевников евразийских степей. М.: Наука.
- Халиль Исмаил. 1983. Исследование хозяйства и общественных отношений кочевников Азии (включая Южную Сибирь) в советской литературе 1950-1980 гг. Автореф. дис. ... канд. ист. наук. М.
- Шнирельман, В.А. 1986. Позднепервобытная община земледельцев-скотоводов и высших охотников, рыболовов и собирателей. История первобытного общества. Эпоха первобытной родовой общины. Отв. ред. Ю.В. Бромлей. М.: 236-426.
- Barfield, T. 1981. The Hsiung-nu Imperial Confederacy: Organization and Foreign Policy. *Journal of Asian Studies* XLI (1): 45-61.



- Barfield, T. 1992. *The Perilous Frontier: Nomadic Empires and China, 221 BC to AD 1757*. Cambridge: Blackwell (First published in 1989).
- Barfield, T. 2000. The Shadow Empires: Imperial State Formation along the Chinese-Nomad Frontier. *Empires*. Ed. by C. Sinopoli, T. D'Altroy, K. Morrison and S. Alcock. Cambridge: Cambridge University Press.
- Gellner E. 1984. Foreword. In: Khazanov A.M. *Nomads and the Outside World*. Cambridge: Cambridge Univ. press, 1984, pp. IX:XXV
- Gellner, E. 1988. *State and Society in Soviet Thought*. Oxford: Oxford University Press.
- Golden, P.B. 1992. *An Introduction to the History of the Turkic Peoples: Ethnogenesis and State Formation in Mediaeval and Early Modern Eurasia and the Middle East*. Wiesbaden: Otto Harrascowitz.
- Golden, P.B. 2001. *Ethnicity and State Formation in Pre-Çinggisid Turkic Eurasia*. Bloomington, IN: Indiana University, Department of Central Eurasian Studies.
- Khazanov A.M. 1981. The Early State Among the Eurasian Nomads. *The Study of the State*. Ed. by H.J.M. Claessen and P. Skalnik. The Hague etc.: 156-73.
- Khazanov, A.M. 1984. *Nomads and the Outside World*. Cambridge: Cambridge University Press.
- Kradin, N.N. 2001. Nomadism and General Theories of Historical Development." *International Symposium on "Dialogue among Civilizations: Interactions between Nomadic and other Cultures of Central Asia"*. Papers. Ulaanbaatar: 263-269.
- Kradin, N.N. 2002. Nomadism, Evolution, and World-Systems: Pastoral Societies in Theories of Historical Development. *Journal of World-System Research* VIII (3): 368-388 (<http://csf.colorado.edu/jwsr>).
- Kradin, N.N., Bondarenko, D.M., Barfield, T. 2003 (eds.) *Nomadic pathways in social evolution*. Moscow: Center for Civilizational Studies.
- Lattimore, O. 1940. *Inner Asian Frontiers of China*. New York etc.: American Geographical Society.